



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 05 өдөр

Дугаар А/608

Алтай хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 20 дугаар тогтоол, Үнэлгээний хорооны 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 135 дугаартай зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгөөр Алтай хотын теле хяналтын камерын системийн нэгдсэн засварын 5S цэвэрлэгээ хийх ажлын гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Цагдаагийн газар (Н.Эрдэнэ-Очир)-т олгосугай.

2.Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Цагдаагийн газар (Н.Эрдэнэ-Очир)-т үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (П.Баасан), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Т.Энхцэцэг), хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгэн авч, эзэмшил, ашиглалтын байдалд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.ГАНБАТ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

0201001643